

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10 үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний талаар	8
2.11 Шилэн дансны мэдээлэл	9
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Н.ЦОГБАДРАХ ТАНАА

2019.03.07 № 06/401
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус хүрээлэнгийн захирал Н.Цогбадрах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 01-нээс 2019 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Ниямазон аудит” ХХК-ийн аудитор Ц.Оюунгэрэл хариуцаж хэрэгжүүлэв.

Зоонозын өвчин судлалын үндэсний төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 1/51 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат, шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн үндсэн зорилго нь байгалийн голомтот зоонозын өвчнийг тандах, хянах эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулахад оршиж байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрмэнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Улсын хэмжээнд байгалийн голомтот, зоонозын халдварт өвчнүүдтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

Хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оновчтой зохион байгуулах, зоонозын өвчний тархалтын судалгааг хийх, хүн амыг уг халдварт өртөх эрсдлээс сэргийлэх;

Зоонозын өвчинтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар санал боловсруулж төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

Улсын хэмжээнд зоонозын өвчний байгаль дахь тархалт цар хүрээ, идэвхжилийг тогтоож, эрсдэлийн дагуу бүсчлэх;

Чиг үүргийн хүрээнд орон нутгийн харъяа байгууллагууд болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, лабораторийн лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх, зоонозын халдварт өвчний мэдээллийн сан бүрдүүлэх;

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Гамшгийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Зоонозын өвчин судлалын даргын 2018 оны Б/86 тоот тушаалаар Монгол улсын засгийн газрын “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 2018 оны 264, “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2018 оны 263 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлж нийт ажилчдын 55 хувь буюу 57 хүний цалинг 2018 оны 9 сараас 1 нээс эхлэн дунджаар 3.9-8 хувиар нэмэгдүүлжээ.

Аудитын явцад төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд зарим эрх зүйн актанд өөрчлөлт орсон байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлж,

мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Зоонозын өвчин судлалын үндэсний төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн онлайн смарт "Unicus" програм хангамжийг ашиглаж байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд Чанар, хяналт үнэлгээ, дотоод аудитын албанд гэрээт дотоод аудитор ажилладаг байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонголоо.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны нийт зардал 2,413,271.1 мянган төгрөгийн 1 хувь болох 24,132.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	5,332.3	
	Дүн	3	5,332.3	

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,983,981.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,951,615.9 мянган төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь цалин болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 29,088.0 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

Тус байгууллага 2018 онд үндсэн бус үйл ажиллагааны орлогыг давуулан биелүүлж 10,762.8 мянган төгрөгийн нэмэлт орлогыг Сангийн сайдын 2017 оны 216 тоот тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын дагуу нэмэлт санхүүжилтэнд тусгуулан ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, урсгал засварын зардалд зарцуулсан байна.

2.10 Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний талаар

Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын дагуу газар, барилга байгууламжийн дахин үнэлгээг санхүүгийн тайлагналын зорилгоор өөрсдийн хүчээр хийж “Файн эстимэйт” ХХК-ийн хөндлөнгийн хараат бус мэргэшсэн үнэлгээчнээр нягтлан шалгалтын ажлыг гүйцэтгүүлсэн ба Нийслэлийн өмчийн харилцааны газраар хянуулсан байна.

“Файн эстимэйт” ХХК-ийн үнэлгээчин тус төвийн 1 газрын эзэмших эрхийг 1,832,157.4 мянган төгрөгөөр, 25 ширхэг барилга байгууламжийг 2,608,252.0 мянган

төгрөгөөр тус тус үнэлсэн. Нийслэлийн өмчийн харилцааны газар газрын эзэмших эрхийг Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтанд заасан 1м.кв газрын 5 дугаар бүсийн үнэлгээгээр тооцож 749,724.7 мянган төгрөг болгон бууруулж, дулааны шугамын элэгдлийг өөрчилсний дүнд барилга байгууламжийн үнэлгээг 1,848,080.7 мянган төгрөг болгон бууруулж залруулсан. Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлтийг хянасан Нийслэлийн өмчийн харилцааны газрын Өмчийн хөдөлгөөн, хувьчлалын хэлтсийн дарга Д. Итгэл, “Файн эстимэйт” ХХК-ийн үнэлгээчин Н.Цолмонгэрэл нараар тус тус баталгаажуулан гарын үсэг зуруулсан байна.

Дахин үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд дараахь байдлаар тусгажээ:

Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороонд байрлах нийт 56583 м.кв газрын эзэмших эрхийг 749,724.7 мянган төгрөгөөр үнэлж, бусад биет бус хөрөнгө болон Засгийн газрын хувь оролцоог нэмэгдүүлсэн;

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 15 барилга, нийтийн эзэмшлийн 5, инженерийн 5 байгууламжийг 1,848,080.7 мянган төгрөгөөр үнэлж, барилга байгууламжийн данс болон дахин үнэлгээний нэмэгдэл дансыг нэмэгдүүлсэн.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тайлант онд нийт 134 мэдээллийг шилэн дансанд оруулсан байна.

Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд нийцүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар, Нийслэлийн өмчийн харилцааны газартай байгуулсан гэрээ эрх зүйн үндэслэлтэй эсэхийг хянуулах 1 зөвлөмж өгсөн. Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь Эрүүл мэндийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Нийслэлийн өмчийн харилцааны газарт хандаж гэрээ хүчин төгөлдөр болохыг хянуулсан бөгөөд зөвлөмж биелсэн гэж үзэж байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бид Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Баримтжуулалт

3.1.1. Зөрчил илрүүлэлт:

Тус төв тайлант онд 5,282.3 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээнд төлбөрийн и-баримт аваагүй байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “бараа, ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”,

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-т “төлбөрийн баримт нь бараа, ажил үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Бараа, ажил үйлчилгээ худалдан авах бүрт нийлүүлэгчээс төлбөрийн и-баримтыг шаардан авч байх

3.1.4. Төсвийн захирагчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.2. Татварын талаар

3.2.1. Илрүүлэлт:

Татвар суутгасан цалин, Хувь хүний орлогын албан татварын тайланд тусгасан цалингаас 50.0 мянган төгрөгөөр илүү зөрүүтэй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6 дэх заалтад “Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 17 дугаар зүйлийн 17.1.1-д “Энэ хуулийн 11.1.1, 11.1.6-д заасан орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр” татвар суутгах орлогыг тодорхойлно гэснийг зөрчсөн байна.

3.2.2. Эрсдэл:

Үнэн зөв байдал-Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тайланг татвар суутгасан цалингийн дүнгээр буюу 50.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж залруулах

3.2.4. Төсвийн захирагчийн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3. Санхүүгийн програмын талаар

3.3.1. Илрүүлэлт:

“Unicus” онлайн смарт програмын аудитын файл цэснээс бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайланд Засгийн газрын капитал дансны үлдэгдэл татагдахгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 47 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн програмд тавигдах шаардлагын 1.10-дэх заалтанд “Санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй ... байх” гэж заасныг зөрчсөн байна.

3.3.2. Эрсдэл:

Үнэн зөв байдал-Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

3.3.3. Өгсөн зөвлөмж:

“Unicus” онлайн смарт програмын аудитын файл цэсний дагуу бэлтгэгдэж буй мэдээллийг "Ординат" ХХК, "Нью-Раданс" ХХК–иудад хандаж залруулга хийлгэх.

3.3.4. Төсөв захирагчийн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>729 753 504,63</u>	<u>671 542 079,73</u>
33	АВЛАГА	2 596 287,00	-
335	Бусад авлага	2 596 287,00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2 596 287,00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	727 157 217,63	671 542 079,73
351	Түүхий эд материал	635 950 382,11	562 865 231,66
35110	Тусгай зориулалттай материал	313 766 104,50	310 838 604,50
35130	Эм боох материал	322 184 277,61	252 026 627,16
354	Хангамжийн материал	91 206 835,52	108 676 848,07
35410	Бичиг хэргийн материал	7 461 451,00	6 420 596,00
35420	Аж ахуйн материал	50 533 607,12	59 556 757,12
35430	Сэлбэг хэрэгсэл	5 646 200,00	5 248 000,00
35440	Түлш, шатах тослох материал	13 195 289,70	16 512 972,19
35450	Барилгын засварын материал	7 181 990,00	12 765 075,00
35470	Бусад хангамжийн материал	7 188 297,70	8 173 447,76
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1 958 719 995,84</u>	<u>3 162 198 033,91</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1 958 719 995,84	3 162 198 033,91
392	Биет хөрөнгө	1 946 666 149,60	2 404 968 079,59
39201	Барилга, байгууламж, орон сууц	3 086 354 157,00	1 895 666 168,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	1 862 066 378,09	6 155 079,80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	290 370 094,00	290 370 094,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	223 004 076,95	244 805 268,85
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1 905 794 916,75	1 988 516 780,84
39206	Хуримтлагдсан элэгдэл	1 346 297 076,34	1 608 632 005,86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	239 201 313,38	249 675 496,88
39208	Хуримтлагдсан элэгдэл	143 686 800,15	159 668 105,62
39214	Бусад үндсэн хөрөнгө	446 551,76	446 551,76
39215	Хуримтлагдсан элэгдэл	446 551,76	446 551,76
393	Биет бус хөрөнгө	12 053 846,24	757 229 954,32
39301	Програм хангамж	25 880 567,10	25 880 567,10
39302	Хуримтлагдсан элэгдэл	13 826 720,86	18 375 362,78
39303	Бусад биет бус хөрөнгө	0,00	749 724 750,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2 688 473 500,47</u>	<u>3 833 740 113,64</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2 688 473 500,52</u>	<u>3 833 740 113,64</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2 688 473 500,52	3 833 740 113,64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1 948 935 905,49	2 698 660 655,49
512	Хуримтлагдсан үр дүн	182 591 433,98	-170 138 872,15
51210	Өмнөх үеийн үр дүн	202 491 219,20	182 591 433,93
51220	Тайлант үеийн үр дүн	-19 899 785,22	-352 730 306,08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	556 946 161,05	1 305 218 330,30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2 688 473 500,52</u>	<u>3 833 740 113,64</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2 187 042 734,14	2 060 540 862,39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	147 496 324,14	79 190 962,39
120	Нийтлэг татварын бус орлого	13 311 815,50	4 045 640,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13 311 815,50	4 045 640,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13 311 815,50	4 045 640,00
122	Тусламжийн орлого	134 184 508,64	75 145 322,39
122001	Хандив тусламж /дотоод/	96 584 388,84	74 345 322,39
122002	Хандив тусламж /гадаад/	37 600 119,80	800 000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2 039 546 410,00	1 981 349 900,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1 870 738 990,00	1 814 364 000,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 737 390 300,00	1 814 364 000,00
131005	Хөрөнгийн санхүүжилт	133 348 690,00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	168 807 420,00	166 985 900,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	168 807 420,00	166 985 900,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2 206 942 519,36	2 413 271 168,47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2 206 942 519,36	2 413 271 168,47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 135 845 817,66	2 307 946 893,36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1 130 926 283,32	1 110 383 452,87
210101	Үндсэн цалин	1 061 079 535,57	709 299 800,00
210102	Нэмэгдэл	-	241 038 262,87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	69 846 747,75	76 774 500,00
210104	Урамшуулал	-	83 270 890,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129 740 389,17	140 753 884,22
210201	Тэтгэврийн даатгал	75 265 355,20	100 345 778,41
210202	Тэтгэмжийн даатгал	8 889 654,64	10 643 500,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	22 080 136,79	8 860 021,59
210204	Ажилгүйдлийн даатгал	2 136 839,98	2 028 500,00
210205	Эрүүл мэндийн даатгал	21 368 402,56	18 876 084,22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79 941 913,31	73 121 216,80
210301	Гэрэл, цахилгаан	28 152 525,00	35 118 898,40
210302	Түлш, халаалт	29 379 177,00	28 639 070,00
210303	Цэвэр, бохир ус	4 024 211,31	4 433 248,40
210304	Байрны түрээс	18 386 000,00	4 930 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	83 534 318,66	90 479 251,07
210401	Бичиг хэрэг	29 320 473,00	14 316 213,00
210402	Тээвэр, шатахуун	38 422 370,00	52 456 417,33
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3 351 818,06	4 676 800,18
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8 526 510,00	10 087 353,94
210408	Бараа материал акталсны зардал	3 913 147,60	8 942 466,62

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	283 402 914,75	378 353 519,83
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	226 122 774,75	356 577 669,83
210502	Хоол, хүнс	56 884 400,00	21 734 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	395 740,00	41 850,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7 118 400	12 341 515
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	149 800,00	697 500,00
210604	Урсгал засвар	6 968 600,00	11 644 015,00
2107	Томилолт, зочны зардал	21 821 450,00	28 579 600,00
210702	Дотоод албан томилолт	21 821 450,00	28 579 600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14 715 944,00	65 633 950,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5 916 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		3 960 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	1 323 000,00	1 555 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	892 200,00	982 200,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	166 300,00	253 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7 872 300,00	20 155 000,00
210807	Газрын төлбөр	3 809 500,00	3 847 600,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	197 144,00	200 000,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	455 500,00	28 765 150,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	384 644 204,45	408 300 503,57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2 512 649,94	3 727 500,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		11 103 300,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	382 131 554,51	393 469 703,57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71 096 701,70	105 324 275,11
2132	Бусад урсгал шилжүүлэг	57 887 255,00	71 544 688,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17 408 000,00	59 520 888,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40 479 255,00	12 023 800,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13 209 446,70	33 779 587,11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13 209 446,70	33 779 587,11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-19 899 785,22	-352 730 306,08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-19 899 785,22	-352 730 306,08

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1 919 509 535,50	1 985 395 540,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3 090 860,50	4 045 640,00
120	Нийтлэг татварын бус орлого	3 090 860,50	4 045 640,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3 090 860,50	4 045 640,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3 090 860,50	4 045 640,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 916 418 675,00	1 981 349 900,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1 916 418 675,00	1 814 364 000,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 737 390 300,00	1 814 364 000,00
131005	Хөрөнгийн санхүүжилт	179 028 375,00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	166 985 900,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	166 985 900,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1 919 509 535,50	1 985 395 540,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 919 509 535,50	1 985 395 540,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 848 412 833,80	1 880 071 264,89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1 133 522 570,32	1 107 787 165,87
210101	Үндсэн цалин	822 867 131,32	709 299 800,00
210102	Нэмэгдэл	151 972 439,00	238 540 265,87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76 774 800,00	76 774 500,00
210104	Урамшуулал	81 908 200,00	83 172 600,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129 740 389,17	140 753 884,22
210201	Тэтгэврийн даатгал	129 740 389,17	140 753 884,22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84 486 913,31	73 121 216,80
210301	Гэрэл, цахилгаан	28 152 525,00	35 118 898,40
210302	Түлш, халаалт	33 924 177,00	28 639 070,00
210303	Цэвэр, бохир ус	4 024 211,31	4 433 248,40
210304	Байрны түрээс	18 386 000,00	4 930 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	80 098 867,00	80 496 498,00
210401	Бичиг хэрэг	27 774 840,00	8 927 598,00
210402	Тээвэр, шатахуун	41 652 420,00	55 774 099,82
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3 058 818,06	4 676 800,18
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7 612 788,94	11 118 000,00
2105	Нормативт зардал	343 355 700,00	323 147 400,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	276 690 100,00	291 632 200,00
210502	Хоол, хүнс	56 884 400,00	21 734 000,00

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9 781 200,00	9 781 200,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34 811 000,00	44 152 900,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	24 605 500,00	24 605 500,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3 920 400,00	4 450 000,00
210604	Урсгал засвар	6 285 100,00	15 097 400,00
2107	Томилолт, зочны зардал	21 821 450,00	28 579 600,00
210702	Дотоод албан томилолт	21 821 450,00	28 579 600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20 575 944,00	70 929 300,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5 916 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	3 960 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	1 323 000,00	1 555 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	892 200,00	982 200,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	166 300,00	253 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8 165 300,00	20 855 000,00
210807	Газрын төлбөр	3 809 500,00	3 847 600,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	197 144,00	200 000,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6 022 500,00	33 360 500,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	11 103 300,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	11 103 300,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71 096 701,70	105 324 275,11
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	57 887 255,00	71 544 688,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17 408 000,00	59 520 888,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40 479 255,00	12 023 800,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13 209 446,70	33 779 587,11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13 209 446,70	33 779 587,11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 948 935 905,49	557 247 384,11	202 189 996,09	2 708 373 285,69
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			301 223,06	301 223,06
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 948 935 905,49	557 247 384,11	202 189 996,09	2 708 373 285,69
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		-301 223,06		-301 223,06
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0,00
C07	Тайлант үеийн үр дүн			-19 899 785,22	-19 899 785,22
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 948 935 905,49	556 946 161,05	182 591 433,93	2 688 473 500,47
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 948 935 905,49	556 946 161,05	182 591 433,93	2 688 473 500,47
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	749 724 750,00	748 272 169,25		1 497 996 919,25
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0,00
D08	Тайлант үеийн үр дүн			-352 730 306,08	-352 730 306,08
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2 698 660 655,49	1 305 218 330,30	-170 138 872,15	3 833 740 113,64

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1 816 995 700,00	1 784 630 052,89	32 365 647,11	98,2%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 816 995 700,00	1 784 630 052,89	32 365 647,11	98,2%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 757 474 800,00	1 725 109 164,89	32 365 635,11	98,2%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1 114 345 200,00	1 089 368 165,87	24 977 034,13	97,8%
210101	Үндсэн цалин	690 880 800,00	690 880 800,00	-	100,0%
210102	Нэмэгдэл	263 517 300,00	238 540 265,87	24 977 034,13	90,5%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76 774 500,00	76 774 500,00	-	100,0%
210104	Урамшуулал	83 172 600,00	83 172 600,00	-	100,0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144 864 900,00	140 753 884,22	4 111 015,78	97,2%
210201	Тэтгэврийн даатгал	89 147 600,00	100 345 778,41	-11 198 178,41	112,6%
210202	Тэтгэмжийн даатгал	11 143 500,00	10 643 500,00	500 000,00	95,5%
210203	ҮОМШӨ-ний даатгал	20 058 200,00	8 860 021,59	11 198 178,41	44,2%
210204	Ажилгүйдлийн даатгал	2 228 700,00	2 028 500,00	200 200,00	91,0%
210205	Эрүүл мэндийн даатгал	22 286 900,00	18 876 084,22	3 410 815,78	84,7%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71 468 800,00	68 191 216,80	3 277 583,20	95,4%
210301	Гэрэл, цахилгаан	36 494 100,00	35 118 898,40	1 375 201,60	96,2%
210302	Түлш, халаалт	29 756 000,00	28 639 070,00	1 116 930,00	96,2%
210303	Цэвэр, бохир ус	5 218 700,00	4 433 248,40	785 451,60	84,9%
2104	Хангамж, бараа материалын зардал	57 821 800,00	57 821 798,00	2,00	99,9%
210401	Бичиг хэрэг	3 007 100,00	3 007 098,00	2,00	99,9%
210402	Тээвэр, шатахуун	39 019 900,00	39 019 899,82	0,18	99,9%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4 676 800,00	4 676 800,18	- 0,18	100,1%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11 118 000,00	11 118 000,00	-	100,0%
2105	Нормативт зардал	292 098 900,00	292 098 900,00	-	100,0%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	282 317 700,00	282 317 700,00	-	100,0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9 781 200,00	9 781 200,00	-	100,0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42 652 900,00	42 652 900,00	-	100,0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	24 605 500,00	24 605 500,00	-	100,0%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4 450 000,00	4 450 000,00	-	100,0%

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	13 597 400,00	13 597 400,00	-	100,0%
2107	Томилолт, зочны зардал	9 871 600,00	9 871 600,00	-	100,0%
210702	Дотоод албан томилолт	9 871 600,00	9 871 600,00	-	100,0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24 350 700,00	24 350 700,00	-	100,0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5 916 000,00	5 916 000,00	-	100,0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3 960 000,00	3 960 000,00	-	100,0%
210803	Даатгалын үйлчилгээ	1 555 000,00	1 555 000,00	-	100,0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	982 200,00	982 200,00	-	100,0%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	253 000,00	253 000,00	-	100,0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5 114 400,00	5 114 400,00	-	100,0%
210807	Газрын төлбөр	3 847 600,00	3 847 600,00	-	100,0%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	200 000,00	200 000,00	-	100,0%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2 522 500,00	2 522 500,00	-	100,0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59 520 900,00	59 520 888,00	12,00	99,9%
2132	Бусад урсгал шилжүүлэг	59 520 900,00	59 520 888,00	12,00	99,9%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	59 520 900,00	59 520 888,00	12,00	99,9%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1 757 474 800,00	1 784 630 052,89	- 27 155 252,89	101,5%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1 754 843 100,00	1 780 584 412,89	-25 741 312,89	101,5%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1 754 843 100,00	1 780 584 412,89	-25 741 312,89	101,5%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2 631 700,00	4 045 640,00	-1 413 940,00	153,7%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2 631 700,00	4 045 640,00	-1 413 940,00	153,7%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	103	103	-	100,0%
620001	Удирдах ажилтан	2	2	-	100,0%
620002	Гүйцэтгэх ажилтан	87	87	-	100,0%
620003	Үйлчлэх ажилтан	14	14	-	100,0%

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Огноо:	Аудитын нэр:	Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019.02.25			САГ-2019//388/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Тус төв тайлант онд 5282.3 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээнд төлбөрийн и-баримт аваагүй байна.	5,282.3	Зөвлөмж өгөх	Төвийн дарга	Н. Цогбадрах
				Нягтлан бодогч	З. Ууганцэцэг
2	Хувь хүний орлогын албан татварын тайланд татвар суутгасан цалинг 50,0 мянгөн төгрөгөөр дутуу тусгасан байна	50.0	Зөвлөмж өгөх	Төвийн дарга	Н. Цогбадрах
				Нягтлан бодогч	З. Ууганцэцэг
3	Unicus програмын аудитын файл цэснээс бэлтгэсэн санхүүгийн тайланд дансны мэдээлэл дутуу татагдаж байгаа		Зөвлөмж өгөх	Төвийн дарга	Н. Цогбадрах
				Нягтлан бодогч	З. Ууганцэцэг
Дүн		5,332.3			

